БАТЛАВ
МӨРӨН СУМЫН ЗАСАГ
ДАРГА Х.ТАЙВАНБАЯР

МӨРӨН СУМЫН ТӨВЛӨРСӨН ХОГИЙН ЦЭГТ ХОГ ХАЯГДЛЫГ ХҮЛЭЭН АВЧ, ДАРЖ БУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭН ЯВУУЛАХ АЖЛЫН ДААЛГАВАР

2025 оны 01 дүгээр сарын 08 Мөрөн сум

1	Шалгаруулалт зохион үндэслэл	Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 340 дүгээр тогтоол, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйл 9.3.8, 9.4.1 дэх заалтууд, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн VII хуралдааны 02 дугаар тогтоолын
2	Захиалагч байгууллага	Мөрөн сумын Засаг даргын Тамгын газар
3	Ерөнхий шаардлага	Сумын хог хаягдлын менежментийг сайжруулах зорилгоор төвлөрсөн хогийн цэгт ирсэн энгийн хог хаягдлыг хүлээн авч, бүртгэх, дарж, булшлах ажлыг гүйцэтгэх
4	Байршил, хог хаягдлын хэмжээ	Байршил: Мөрөн сумын 13 дугаар багийн нутаг дэвсгэр Хог хаягдлын хэмжээ: Дунджаар 28,000 тонн/жил /*"Элстийн ар" хогийн цэгийн 2020-2024 оны хог хаягдлын бүртгэлээс* /
5	Үндсэн үйл ажиллагааны үндсэн шаардлага	5.1. Төвлөрсөн хогийн цэгийн үйл ажиллагааг Хог хаягдлын тухай хуульд нийцүүлэн зохион байгуулна. 5.2. Энгийн хог хаягдлыг ландфиллын талбайд дарж, булшлах хэсэгчилсэн төлөвлөлтийг жил, улирлаар боловсруулж, ажлын төлөвлөгөөг гарган ажиллана. 5.3. Төвлөрсөн хогийн цэгт зөвшөөрөлгүй хүн, мал амьтан нэвтрүүлэхгүй байх арга хэмжээг авч ажиллана. 5.4. Төвлөрсөн хогийн цэгт ашиглах зориулалттай тесвийн хөрөнгөөр авсан дараах эд хөрөнгийн ашиглалт хамгаалалтыг бүрэн хариуцна. Үүнд: машин, техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, газар эдэлбэрт хамаарах гэрэлтүүлэг, цахилгаан хангамж, хашаа, хяналтын камер, холбоо мэдээллийн шугам, автопүү, бүртгэлийн байр гэх мэт. 5.5. Төвлөрсөн хогийн цэгт ирсэн хог хаягдлыг зориулалтын программ хангамжаар эх үүсвэр тус бүрээр төрөлжүүлэн хэмжилт бүртгэл хийх ба бүртгэлийн мэдээллийн сангийн аюулгүй байдал, үнэн зөвийг бүрэн хариуцна. 5.6. Ландфиллын талбайд хог хаягдлын түрэлт, нягтруулалтыг төлөвлөлтийн дагуу өдөр бүр тогтмол хийж, 70-200 см өндөржилттэй хог хаягдал тутамд 15-30 см зузаан хөрсөөр хучилт хийнэ. 5.7. Метан хий зайлуулах хоолойг хог хаягдлын өндөржилт 2 метрээс дээш гарсан тохиолдолд тухай бүр нэмэлтээр болон шинээр суурилуулна.

		5.8. Хог тээврийн машин ландфиллын талбайд хог буулгах нягтруулсан шороон замыг тогтмол гаргаж, машин техникийн дугуйг хагалахгүй байх, хог хаягдлыг аюулгүй буулгах нөхцөлийг хангаж ажиллана. 5.9. Хогийн цэг доторх болон ойр орчмын хөрс, ус, агаарын чанарыг жилд 1-ээс доошгүй удаа шинжлүүлж, хяналт мониторинг хийж ажиллана.
6	Техник, тоног төхөөрөмжийн шаардлага	6.1. Дараах үндсэн техник, тоног төхөөрөмжтэй байна: - 50 ковш – 1 /Хог түрэх, хучилтын шороо ачих/ - Бульдозер – 1 /Хог түрж, нягтруулах, хучилтын шороо түрэх, нягтруулах/ - Экскаватор – 1 /Хучилтын шороо бэлтгэх/ - Задгай тэвштэй хүнд даацын ачааны автомашин - 1 6.2. Хог хаягдлыг дарж, булшлах зориулалтын стандартын шаардлага хангасан техник хэрэгслийг ашиглана.(GPS хяналтын системтэй байна.) 6.3. Машин, техникийг сард 1 удаа, улиралд 1-ээс доошгүй удаа халдваргүйжүүлэх 6.4. Засвар үйлчилгээ хийх боломжтой өөрийн болон түрээсийн гарааш, багаж хэрэгсэлтэй байна.
7	Хүний нөөцийн шаардлага	Үйл ажиллагааг хэвийн явуулах дараах орон тоотой байна: • Захирал – 1 хүн • Механик инженер – 1 хүн • Менежер ба ХАБЭА инженер – 1 хүн • Нягтлан бодогч, нярав – 1 хүн • Талбайн чиглүүлэгч – 1 • Бүртгэлийн ажилтан – 3 хүн • Машин механизмын оператор, жолооч – 3-4 хүн
8	Мөрдөх хууль, норм, стандарт	8.1. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 122 дугаар тогтоолоор батлагдсан журам 8.2. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 46 дугаар тогтоол 8.3. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн холбогдох хууль, дүрэм, стандартууд
9	Онцгой нөхцөл ба хориглолт	9.1. Хог хаягдлын тухай хуулиар хориглосон бүхий л үйл ажиллагааг хориглоно. 9.2. Гал, шаталтын эрсдэл үүсэхээс сэргийлж, гарсан тохиолдолд шуурхай арга хэмжээ авч унтраана. 9.3. Төвлөрсөн хогийн цэгийн орчимд салхиар тархаж хийссэн хог хаягдлыг тогтмол цэвэрлэнэ. 9.4 Өөр төрлийн хог хаягдлыг бууруулах чиглэлээр шинэлэг арга технологи нэвтрүүлэх санал ирүүлсэн бол давуу тал болно 9.5 Төвлөрсөн хогийн цэгийн ашиглалт үйл ажиллагааны гэрээг 3 жилээр хийх ба гэрээг жил бүр дүгнэнэ. Ажлын даалгаварт заагаагүй бусад шаардлагуудыг гэрээнд тусгах байдлаар зохицуулна.
10	Гэрээнд тусгах тусгай нөхцөл	10.1. Үйл ажиллагааг хангалтгүй гүйцэтгэсэн, эсхүл төвлөрсөн цэгээс гадуур хог хаягдал их хэмжээгээр үүсгэсэн тохиолдолд гэрээг цуцлах үндэслэл болно.

		10.2. Гэрээ цуцлагдсантай холбоотой үүсэх хохирол, зардлыг гүйцэтгэгч байгууллага бүрэн хариуцна. 10.3. Төвлөрсөн цэгийн эд хөрөнгийг захиалагч байгууллагатай байгуулсан гэрээний үндсэн дээр ашиглана.
11	Тайлан	Хогийн цэгийг түрж булах ажил гүйцэтгэсэн тайлан мэдээг дараах байдлаар ирүүлнэ. Үүнд 11.1 Гүйцэтгэлийн тайлан мэдээг сар бүр загвар маягтын дагуу гаргаж холбогдох мэргэжилтэнд ирүүлнэ. 11.2 Ажлын гүйцэтгэлийг бичгээр тайлагнах ба түүнийг фото зургаар баталгаажуулна. 11.3 Сарын тайланд хог хаягдлын үйлчилгээний орлогын төлөвлөгөөг хэрхэн биелүүлж ажилласан талаар баримт нотолгоотой тусгаж оруулна. 11.4 Өдөр тутмын ажлын өмнөх болон дараах зургийг цахим программ эсвэл группээр тайлагнаж ажиллана. 11.5 Явцын хяналттай уялдуулан ирүүлсэн тайланд үнэлгээ хийж гүйцэтгэлийг сар бүр үнэлнэ. 11.6 Улирал бүр ажлын тайланг Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулна. 11.7 Гэрээг улирлаар нь дүгнэж ажиллах ба гүйцэтгэлийн үнэлгээ 50% доош үнэлэгдсэн тохиолдолд хамтран ажиллах гэрээг дуусгавар болгоно.
12	Санхүүжилт	Төсвөөс олгох санхүүжилт: Сар бүр батлагдсан хуваарийн дагуу санхүүжилт олгох ба ажил гүйцэтгэл 11 сарын хугацаанд үйл ажиллагааг эрхэлнэ. **Жич:** Санхүүжилтийг тухайн сарын ажлын гүйцэтгэлд үндэслэн олгоно.

ХЯНАСАН:
МӨРӨН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ Б.ДУГАРАА

БОЛОВСРУУЛСАН АЖЛЫН ХЭСГИЙН ГИШҮҮД:

СУМЫН ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САН ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН Л.ОЮУН-ЭРДЭНЭ

ГИШҮҮН: СУМЫН ИРГЭДИЙН ХУРЛЫН ТӨЛӨӨЛӨГЧ У.ХҮЧИТБААТАР

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА: ХОГ ХАЯГДАЛ, ОРЧНЫ ЭРҮҮЛ АХУЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН АЖИЛТАН Б.АНХЦЭЦЭГ

Хавсралт мэдээлэл

1. Хог хаягдлын цэгийн зураг

2. Хогийн цэгийн 1,2,3 дугаар талбайн хэмжээ
    - 1-р талбай – 2.4 га талбай
    - 2-р талбай - 2.8 га талбай
    - 3-р талбай – 0.8 га талбай
3. Хогийн цэгийн хил хязгаар, талбайн хэмжээ
   1,2,3-р талбайн хэмжээгээр хязгаарлагдана.
4. Хогийн цэгт өдөрт ирдэг машины тоо, хог хаягдлын хэмжээ, сар сараар
    - Өдөрт дунджаар ирэх машины тоо – 40 - 50
    - Өдөрт хүлээн авах дундаж хогны хэмжээ – 112,9 тн
    - Сард ирдэг авто машины рейсийн тоо – 1237
    - Сард хүлээн авах дундаж хогны хэмжээ – 3368,8 тн
5. Хогийн цэгт ашиглагдаж байгаа машин техник, тоног төхөөрөмж, барилга байшин, дэд бүтцийн байгууламж гэх мэт
    - Нэвтрэх цэгийн автомат хаалт, дугаар бүртгэх камер
    - Хашаа 16 м
    - Пүүний бүртгэлийн байр
    - Пүүний программ, компьютер, дэлгэц
    - 4 камер, 4 метр шон 4 ш
6. Сумын төвөөс алслагдсан зай
   Хөвсгөл аймгийн төв Мөрөн сумын төвлөрсөн хогийн цэг нь сумын төвөөс 6км зайд оршдог.

Image © 2025 Airbus